


Өвлийн саруудад Монгол орны нутаг дэвсгэр дээгүүр их даралтын орон зонхилон ажиглагддагтай холбоотой цаг агаар гол төлөв тогтуун байдаг. Манай орны хамгийн хүйтэн 1 дүгээр сарын агаарын дундаж температур (1991-2020 оны дунджаар) Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутаг болон томоохон гол, нуурын сав газраар -21°C (-5.8°F) –аас хүйтэн, говь-цөлийн бүс нутгаар -7°C (19.4°F) –аас -16°C (-3.2°F), бусад нутгаар -18°C –аас -21°C (-0.4°F –аас -5.8°F) хүйтэн байдаг байна.


Монгол орны хэмжээнд 1 дүгээр сард хур тунадас бага унадаг ба ойролцоогоор жилийн нийлбэр хур тунадасны 1 хувьтай тэнцдэг. Тус сард томоохон гол, нуурын сав газар болон Ховдын урд, Увсын зүүн хойд, Завханы хойд, Дорнодын зүүн нутгаар 2-4 мм, Баян-Өлгий, Увсын зүүн хэсэг, Ховдын зарим нутаг, Баянхонгорын урьд хэсэг, Дундговийн зүүн хэсэг, Дорноговийн ихэнх нутгаар 1 мм –ээс бага, бусад нутгаар 1 –ээс 2 мм тунадас ордог байна.



Зураг 1. 1991-2020 оны 01 дүгээр сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны оронзайн тархалт


2026 оны 1 дүгээр сарын агаарын дундаж температур өмнөх жилээс -3.7°C , харин ОЖД-ийн орчим хүйтэн сар болж өнгөрлөө. Сарын дундаж агаарын температурын ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалтыг авч үзэхэд (Зураг 2) нутгийн 34.1% нь дунджаас 1.1-ээс 4.5°C дулаан, 41.1% нь дунджийн орчим, 24.8%-д нь дунджаас -1.1 -ээс -4.4°C хүйтэн байжээ.

Тус сард Монгол орны хэмжээнд дунджаар 1.9 мм хур тунадас орсон нь өмнөх жилээс 15.3%-иар бага, ОЖД-аас 12.6%-иар ахиу хур тунадас орсон бөгөөд 1940 оноос хойш тохиолдож байгаа 29 дэх хур тунадас ихтэй сар болж өнгөрлөө. Сарын нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалтыг авч үзвэл (Зураг 2) нийт нутгийн 39.5% нь дунджаас ахиу, 3.9% нь дунджийн орчим, 56.6% -д бага хур тунадас унасан байна.




Зураг 2. 2026 оны 01 дүгээр сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын оронзайн тархалт

Монгол орноор болон 4 бүсээр ангилан дунджилсан 1 дүгээр сарын хоногийн дундаж агаарын температурын явцыг авч үзэхэд (Зураг 3)) сарын эхнээс 2 дугаар арав хоногийн дунд хүртэл ихэнх нутгаар дунджаас дулаан, ялангуяа баруун, төв, өмнө зүгийн нутгаар зарим өдрүүдэд ОЖД-аас 3.5-аас - 12.6°C-аар дулаан, харин 2 дугаар 10 хоногийн дундаас огцом хүйтрэлт ажиглагдаж, агаарын температур ОЖД-аас -5-аас -12.5°C-аар хүйтэрсэн. 3 дугаар 10 хоногийн дундаас баруун болон өмнө зүгийн нутгаар агаарын температур дунджаас дулаан байжээ. Хур тунадасны хувьд 1 дүгээр 10 хоногийн сүүлээр ихэнх нутгаар, 2 дугаар 10 хоногт нийт нутгийг хамран харьцангуй ахиу хур тунадас орсон бол 3 дугаар 10 хоногт бараг хур тунадас ажиглагдаагүй байна.



Зураг 3. Хоногийн агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлт


Агаарын үнэмлэхүй бага температур -30°C-ыг давж хүйтэрсэн өдрийн тоо Увсын Улаангом, Тэс, Баруунтуруун, Малчин, Завханы Отгон, Баянтэс, Тосонцэнгэл, Баянхонгорын Байдраг, Хөвсгөлийн Цагаан-Үүр, Ренчинлхүмбэ, Сэлэнгийн Ерөө орчмоор 25-31 өдөр, Завханы Завханмандал, Цэцэн-Уул, Нөмрөг, Хөвсгөлийн Баянзүрх, Эрдэнэбулган, Чандагат, Сэлэнгийн Сүхбаатар, Орхонтуул, Орхон, Булганы Тэшиг, Хэнтийн Өндөрхаан, Төвийн Алтанбулаг, Лүн, Дорнодын Халхгол, Улаанбаатарын Буянт-Ухаа, Багануур орчмоор 20-24 өдөр, бусад нутгаар 5-19 өдөр ажиглагдсан бөгөөд нутгийн өмнөд хэсгээр ажиглагдаагүй.



Зураг 4. -30°C-аас хүйтэн өдрийн тооны газарзүйн тархалт

Энэ сард температурын үнэмлэхүй бага утга Завхан аймгийн Баянтэс/ Баян-Уул/ суманд агаарт -51.1°C , хөрсөнд -53°C хүрч хүйтэрсэн. Харин температурын үнэмлэхүй их утга Ховд аймгийн Зэрэг суманд агаарт 7.5°C , хөрсөнд 14°C хүрсэн байна. Агаарын температурын үнэмлэхүй бага утга Хөвсгөлийн Цэцэрлэгт -46.3°C , Төвийн Баянчандманьд -39.7°C , Хэнтийн Оргилд -37.9°C , Өвөрхангайн Төгрөгт -37.1°C , Сүхбаатарын Эрдэнэцагаанд -38°C хүрч эвдэгдсэн байна.

Хоногт хамгийн ихдээ Булган аймгийн Сэлэнгэ/Ингэттолгой/ суманд 14-ний өдөр 4.5 мм хур тунадас (цас) орсон. Харин даралтын үнэмлэхүй их утга Сэлэнгийн Сүхбаатарт 969.1гПа, бага утга Баянхонгорын Баянбулагт 760.6гПа хүрч тус тус ажиглагдсан. Салхины хурд хамгийн их нь Баянхонгор аймгийн Баянцагаан суманд 31м/с хүрчээ.



Зураг 5. Тус сард ажиглагдсан экстремаль утгууд